# САНХҮҮ БҮРТГЭЛ ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын нэр НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Зохион байгуулалтын нэгж САНХҮҮ БҮРТГЭЛ ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТЭС

*Төлөвлөгөөг хянасан:*

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА ........................ (С.НЯМЖАВ)

*(гарын үсэг)*

*(огноо)*

2024.12.09

*Төлөвлөгөө тайлагнасан:*

САНХҮҮ БҮРТГЭЛ ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА ........................................(Б.БАДАМГАРАВ)

*(гарын үсэг)*

*(огноо)*

....................

## САНХҮҮ БҮРТГЭЛ ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүссэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **_Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт._** | | | | | | | |
| _“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах”_ **_гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:_** | | | | | | | |
| 1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах /1.1.1/ | | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Засгийн газрын тогтоол-1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал-6, албан даалгавар-1, НДҮЗ-ийн тогтоол-1, НДЕГ–аас ирүүлсэн 48 тушаал албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг хангаан ажиллаж үүнээс хугацаатай 16 бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. НДЕГ-аас ирсэн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголт өгөхөөр сумдын байцаагчдад хүргүүлэн ажиллаж байна. | |
| 1.2. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх /1.1.2/ | | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | 2023 онд 984 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 634 малчин шинээр хамруулав. | Сайн дурын даатгалд 2024 онд 948 даатгуулагч, үүнээс 600 малчин даатгуулагчийг шинээр хамруулж, хамралтын төлөвлөгөөг биелүүлсэн байна | 2024 оны жилийн эцсийн ,байдлаар сайн дурын даатгалд шинээр 1261 даатгуулагч, үүнээс шинээр 848 малчин даатгуулагчийг хамруулсан. Нийт сайн дураар нийгмийн даатгалд 5278 иргэн хамрагдан даатгуулсан байна. Сайн дурын даатгалын хамралт зорилтот түвшингээс 12.8 хувь, малчин шинээр хамралт 14.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. /1.1.3/ | | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | 2023 онд 67 ажил олгогч, 477 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав. | Ажил олгогчийн тоог 63, даатгуулагчийн тоог 292-оор нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд 63 аж ахуйн нэгж хамруулахаас 2024 онд 83 аж ахуй нэгж бүртгүүлж 131.7 хувь, шинээр заавал даатгалд 292 даатгуулагч хамруулахаас 808 даатгуулагчийг шинээр хамруулж 276 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | |
| 1.4. | Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын жилийн төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах . | | 2024 оны Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын жилийн төсвийн төсөл, төсөөлөл бүрэн хийгдсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийг хугацаанд нь хийж хүргүүлсэн. | Төсөл, төсөөллийг хугацаанд нь хийж хүргүүлсэн байна. | Газрын даргын 2024.05.31-ний өдрийн А/23 тоот тушаалаар төсвийн төсөөллийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Газрын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны дунд хугацааны төсөөллийн саналыг хугацаанд нь бэлтгэн хүргүүлсэн. 2025 оны цалингийн сангийн төсвийн төслийг ажилтан нэг бүрээр үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, ур чадвар, орон нутгийн нэмэгдэл болон бусад нэмэгдлийг тооцон хийсэн.Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн төслийг 2384069.40 мянган төгрөг, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төслийг нийт орлого 37267852.04 мянган төгрөг, нийт зарлагыг 136718346.27 мянган төгрөгөөр тооцон НДЕГ-т 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлсэн. | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах./2.1.1/ | | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 34,550.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 88,878.9 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.. | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 45027397.9 мянган төгрөгөөр буюу 106.8 хувиар биелүүлсэн. Зардлын төлөвлөгөө- 119286351.3 мянган төгрөг, 119047778.6 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 99.8 хувийн гүйцэтгэлтэй байсан. | |
| 2.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. /2.1.2/ | | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1,379.8 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 2150122.1 мянган төгрөгийг батлагдсанаас 2060360.6 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, 89761.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан. | |
| 2.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх /2.1.3./ | | Батлагдсан 38 732 689.80 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 31 838 046.65 мянган төгрөгөөр буюу 90.4 хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын санд 38 732 689.80 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 42160485.0 мянган төгрөг, гүйцэтгэл 45027397.9 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 106.8 хувиар биелүүлсэн байна. | |
| 2.4. | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх./2.1.4/ | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 4 197 019.08 мянган төгрөг төвлөрсөн байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | НДЕГ-ын 2024.01.12-ны өдрийн 01/105 тоот чиглэлийн дагуу даатгуулагчид төлбөл зохих шимтгэлийг нь тооцож мэдээлэл, ebarimt- цахим төлбөрийн системээр төлүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 2024 оны 01 дүгээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сард 1881.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. | |
| 2.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. /2.1.5/ | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 144.3 хувиар өссөн байна. Уул уурхайн 2 компани шинээр байгуулагдсанаас үүссэн. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна. | Оны эхний НДШ-н авлагатай 191 байгууллагын 869721.5 мянган төгрөгнөөс 178 байгууллагын 765140.6 мянган төгрөг буюу нийт авлагын 87.9 хувийг бүрэн барагдуулсан. Ойн баялаг ХХК-ийн 1546.0 мянган төгрөгийг авлагыг барагдуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаж бүрэн барагдуулсан. | |
| 2.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах /2.1.6/ | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар 387 сайн дурын даатгуулагчийн 12330.4 мянган төгрөгний шимтгэлийг өглөгийг шилжүүлсэн. | |
| 2.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах /2.1.7/ | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | 1.Ажил олгогчийн илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй 289 байгууллагын 48223.5 мянган төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулсан.<br>2. Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны авлагын үлдэгдлийг шинэчлэн баталгаажуулсан боловч "Олон өргөө ХХК"-наас авах 4484,7 мянган төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлага нь анх 2007 онд үүссэн бөгөөд Улсын бүртгэлийн газраас мэдээллийг авахад " Олон өргөө ХХК" нь 2015 онд улсын бүртгэлээс хасагдсан байна. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 101/32024/20939 дугаартай | ? |

-45-

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжийг хүлээн авч, хэргийн материалтай танилцан цаашид хэрхэн ажиллах нөхцөл боломжийг судлан ажиллаж, хууль зүйн туслалцааны төвийн Завхан аймаг дахь салбарт хандан 2024 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн 1/87 дугаартай Хууль зүйн дүгнэлт гаргуулан Завхан аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсний үр дүнд 2024 оны тайланд залруулга хийлгэн хасуулахаар шийдвэрлүүлсэн. | |
| 2.8. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. /2.1.8/ | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | НДЕГ-ын төвлөрсөн харилцах дансанд жилийн эцсийн байдлаар нийт 49267952.8 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн. | |
| 2.9. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. /2.1.9/ | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 117 602 323.80 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 117 602 323.80 төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | 1. Тэтгэврийг арилжааны банкуудтай хамтран сар бүрийн 01-ний өдөр олгож байна. Банкуудтай тохирсон өдрүүдэд жагсаалтаар тэтгэврийг олгож байна.<br>2. Зардлын төлөвлөгөө- 119286351.3 мянган төгрөг, 119047778.6 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 99.8 хувийн гүйцэтгэлтэй байсан. | |
| 2.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. /2.1.10/ | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй | Батлагдсан 1 443 951.9 мянган төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1 379 856.3 мянган төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, | 1. Төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр бараа үйлчилгээний бусад зардлаас 89761.5 мянган төгрөгийн зардал хэмнэсэн.<br>2 Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 2150122.1 мянган төгрөгийг батлагдсанаас 2060360.6 мянган | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллана. | | шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, 89761.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан. 3. Нийгмийн даатгалын байгууллагын НДШ-ын авлага 278.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, шинээр өглөг авлага үүсгэлгүй ажилласан. | |
| 2.11 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах /2.1.11/ | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, Нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, Нийгмийн даатгалын сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг тус тус 12 удаа хугацаанд нь хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, сангийн нэгдсэн санхүүгийн тайланг 4 удаа хугацаанд нь үнэн зөв гарган НДЕГазарт тайлагнасан. | |
| 2.12 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. /2.1.12./ | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/92 журмын дагуу хөрөнгө, эд аж ахуйн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж гүйцэтгэсэн. Тооллогоор нийт 483 ш 634069.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 14877.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, илүүдсэн дутагдсан хөрөнгө илрээгүй. Газрын үндсэн хөрөнгийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудасны burtgel.pcsp.gov.mn холбоосонд байршуулсан "Төрийн болон орон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүллэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, | нутгийн өмчийн тооллогын систем"-ийн программ хангамжид 2023 оны үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг бүрэн оруулан ажилласан. Төрийн өмчийн эзэмшүүлэх гэрээний биелэлт 84.0 хувь үнэлүүлсэн. Байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах комисс шинэчлэн байгуулагдаж 8 удаа хуралдаж эд хөрөнгийн тооллого, актлах болон дахин үнэлүүлэх хөрөнгийн судалгаа жагсаалт дүгнэлтүүдийг гарган ажилласан байна. Элэгдлээрээ өртгөө нөхөж, үлдэх өртөггүй болсон 26 нэрийн 109ш 26748.7 мянган төгрөгийн хөрөнгийн актлуулахаар хэлтсийн "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д хүргүүлэн дүгнэлт гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн газрын даргын 518 тоотоор хүргүүлэн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | | |
| 2.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. /2.1.13./ | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна | а) Нийгмийн даатгалын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлгэж "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар 25041.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд зөрчил давтан гаргаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг https://fas.audit.mn/-д хугацаанд нь оруулан тайлагнасан. | |
| 2.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. /2.1.14/ | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Арилжааны банктай байгуулсан гэрээнд өдөр бүрийн үлдэгдэлд хүү тооцон 65201.8 мянган төгрөгийг хүүгээр бүртгэсэн. Тэтгэвэр тавьж олгосны банкны үйлчилгээний хөлсөнд 6085.9 мянган төгрөг шилжүүлсэн. | |
| 2.15. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. /2.1.15/ | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийн НББ дэд системд аж ахуйн нэгж, байгууллага болон сайн дурын даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг, ажил олгогч, даатгуулагчаар таниулан бүртгэж байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийг төрлөөр, банкаар бүртгэж өглөгөө хааж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | | |
| 2.16. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. /2.1.16/ | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг оны эхнээс үе шаттай нэвтрүүлж байна. НББ дэд системд банкны хуулга татах, орлого таниулах, өглөг хаах ажлыг хийж гүйцэттэж байна. | |
| 2.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах /2.1.17/ | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | 1. Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны авлагын үлдэгдэл болох "Олон өргөө ХХК"-наас авах 4484,7 мянган төгрөгийн найдваргүй авлагыг холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэн, Завхан аймгийн Төрийн аудитын газрын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд 2024 оны тайланд залруулга хийлгэн хасуулахаар шийдвэрлүүлсэн.<br>2. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр шинэчлэн, сумдын байцаагчид болон газрын хариуцсан байцаагчидтай тооцоо нийлж баталгаажуулан ажиллаж байна. | |
| 2.18. | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх /2.1.18/ | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо | 1.ЭМД-ын харилцах дансуудыг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс ашиглахгүй болсонтой холбоотойгоор НДЕГ-т 1881.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн, уг дансыг хаасан.<br>2.ЭМД-ын ташаарсан 316 даатгуулагчийн 6609.7 мянган төгрөгний орлогын жагсаалтыг гаргаж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлэн ажилласан. | |

-50-

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | | |
| 2.19 | Шилэн дансны хуулийн дагуу санхүү, бүртгэлийн мэдээллийг байршуулах | | Шилэн дансны хууль хэрэгжсэн байна. | Мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан. | Мэдээ, мэдээлэл хугацаандаа бүрэн байршуулах | 2024 оны жилийн эцсийн байдлаар "Шилэн дансны хууль"-ийн хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны цахим хуудсанд "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 171 удаа мэдээлэхээс хугацаандаа 171, Газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 182 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 182 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн. | |
| **_Гурав. Байгууллагын болон нэгжийн зохион байгуулалтыг хангах, хэрэгжүүлэх, хяналт тавих_** | | | | | | | |
| 3.1 | Нэгжийн байцаагчдын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангаж ажилла | | Нэгжийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулна | Нэгжийн байцаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах санал боловсруулж хугацаанд нь биелэлтийг тооцон дүгнэсэн. | А) Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг хангасан байна.<br>Б) Нэгжийн байцаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, | А.Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Б. Санхүү бүртгэлийн тасгийн байцаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалтыг хянаж, биелэлтийг хагас бүтэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | биелэлтийг тооцсон байна. | жилээр үнэлж үнэлгээний багт хүргүүлсэн. | |
| 3.2 | Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой албан бичиг, тушаал шийдвэрийг төлөвлөх, хянуулах, батлуулах | | Хугацаатай бичиг тоот, судалгааны тоогоор | Тухайн хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлсэн. | Тасгийн хугацаатай бичиг тоот, судалгааг хянаж, батлуулсан байна. | НДЕГ болон холбогдох дээд байгууллагаас тушаал, албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж үүнээс хугацаатай 16 бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн байна. | |
| 3.3 | Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар судалгаа шинжилгээ хийж санал, зөвлөмж, мэдээлэл бэлтгэж, байцаагч, ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангах | | Тасгийн болон сумдын байцаагчдыг мэргэжил аргазүйгээр хангасан байна. | Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, сумдын болон хэлтсийн байцаагчдад сургалт хийсэн. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2025 оны төсвийн төсөл боловсруулахад шаардлагатай малчдын тоо, тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо, түүнтэй холбоотой гарсан зардлын судалгааг гаргаж, байцаагчид хүргүүлэн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн хуримтлагдсан авлага, өглөгийн судалгаа гаргаж ХНХСайдын А/199 тоот тушаалаар батлагдсан журмыг сумын байцаагчид хүргүүлэн мэргэжил арга зүйгээр хангаж ажилласнаар өглөг авлага буурсан. | |
| 3.4 | Цаг үеийн шинж чанартай бусад үйл ажиллагаанд оролцох, хэрэгжилтийг хангаж ажиллах | | Үйл ажиллагааны тоогоор | Тухайн хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлсэн. | Мэдээллийн цагийг зохион байгуулж, албан даалгаврын хэрэгжилтийг хангасан байна. | 1.Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд газрын хамт олон мод тарьж, зүлэгжүүлж, арчилж усалж байна.<br>2. ."Хаврын их цэвэрлэгээ"-нд Улиастай сумын малын ченжийн захын ойролцоох газрыг хэлтсийн 20 албан хаагч цэвэрлэн 1 удаа хогийг ачуулж хүлээлгэн өгсөн.<br>3.Газрын байрны дотор ханыг эмульсээр будаж, тохижилтыг хийж ажилласан.<br>4.2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Аймгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургуулалтанд хамрагдсан.<br>5.Монголын Хуульчдын холбооноос жил бүрийн 05-р сарын 01-ний өдрийг ПРО-БОНО зарласантай холбоотойгоо арга хэмжээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцож иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.<br>6."Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг аймгийн төвд баруун бүсийн худалдааны төвийн талбайд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл, брошур тарааж гар утасны аппликейшн суулган өгч ажилласан. | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. /4.1.1/ | ---- | Монгол улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 онд ЗГ тогтоол-4, НДҮЗ тогтоол-3, ХНХЯС тушаал-3, ХНХС-ын албан даалгавар-3, НДЕГ тушаал-20 хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна. | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | НДЕГ–аас ирүүлсэн 48, аймгийн ЗДТГ-аас болон бусад байгууллагаас ирүүлсэн 4 тушаал албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж үүнээс хугацаатай 16 бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. | |
| 4.1.2 | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх /4.1.5/ | ---- | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Ажлын байрны чиг үүрэг дүн шинжилгээ хийж 2 ажилтны ажлын байрны ачааллыг тэнцвэржүүлэн зохион байгуулсан. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | 1.Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулахаар төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан ажиллаж байна.Тус төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулан газрын албан хаагч 4-6 ажил олгогч хариуцан ажиллаж байна. Тухайн хариусан ажил олгогч руу утасаар болон биеэр уулзалт зохион байгуулж, шимтгэлийн өртэй ажил олгогчдод өрөө барагдуулах, алданги тооцох тухай, нийгмийн даатгалын сангаас ажилтнуудад тэтгэвэр, тэтгэмж олгохгүй тухай мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж байна. Үүний үр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүнд оны эхний НДШ-н авлагыг 87.9 хувийг барагдуулсан.<br>2. Складанд хадгалагдаж байгаа эд хогшил хөрөнгийг шинэ, хуучин, актлагдах зэргээр нь ялган агуулахын өрөөний эмх цэгцийг сайжруулсан.<br>3. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт амаржсан сайн дурын даатгалд хамрагддаггүй болон энгийн сайн дурын даатгуулагч эхэд 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхээр буюу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу хөнгөлөлттэй нөхцөлөөр сайн дурын даатгалд даатгуулах урилга өгөхөөр бэлтгэн ажиллаж байна. | |
| 4.1.3 | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах /4.1.8/ | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | НДЕГ-ын 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.<br>1.Газрын гаднах хаяг, байцаагч ажилтнуудын өрөөний хаяг зэргийг НДЕГ аас ирүүлсэн стандартын дагуу хийж байршуулсан.<br>2.Газрын 1-3 давхрын заалны хана, коридор, 2 өрөөний дотор талыг албан хаагчид өөрсдийн хүчээр эмульсдэж, өнгө үзэмжийг сайжруулсан. | |
| 4.1.4 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх<br>Ажил олгогчийн | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | 1. Sicos програм нь улсын хэмжээнд ажил олгогч нарын мэдээллийг шүүж харах нөхцөл боломж бүрдсэн ба шинээр бүртгүүлсэн ажил олгогч нарын мэдээллийг тухай бүр нь | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлсэн байх /4.4.1/ | | НДШ-ийн тайланд иргүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх<br><br>Ажил олгогчоос цахимаар иргүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br><br>Ажил олгогчоос цахимаар иргүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | бүртгэж оруулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татдаг болсон тул ажил олгогчийн мэдээллийн зөрүүтэй байдал үүсээгүй байна.<br>2. Мэдээллийн шинэ систем нэвтэрсэнтэй холбогдуулан нийт ажил олгогчийн дарга, нягтлан бодогч нарт ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийнн төрлийн кодоор цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан. Тайланд даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилалыг "Улсын ажил мэргэжлийн ангилал, тодорхойлол"-д заасан стандартын дагуу зөв сонгож тайлагнадаг болсон.<br>3. Даатгуулагчийн тушаалын мэдээлэл оруулах зааварчилгаар бүх ажил олгогч нягтлан бодогч нарт өгсөн ба тушаалын өөрчлөл хийгдэхгүй байгаа даатгуулагч нарын мэдээллийг тухай бүр нь шинэ системд засварлаж ажилласан. | |
| 4.1.5 | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх /4.4.2/ | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх<br><br>Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.<br><br>Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.<br><br>Сайн дурын даатгуулагчийн | 1. Сайн дурын даатгуулагчийн гэрээг давхардуулан бүртгэхгүй байна. Өмнөх оны үргэлжилсэн сайн дурын даатгуулагчийн гэрээг дуусгавар болсны дараагийн сард сунгасан. Sicos програмын талаар иргүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн ажилласан.<br>2.Сайн дурын даатгалын гэрээний эхлэх хугацаа болон гэрээний дүн буруу хийгдсэн 76 даатгуулагчийн гэрээг цуцалж засварласан.<br>3. Сайн дурын даатгуулагчийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийгээгүй. | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 5 | 7 |
| 1 | Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн шинэчлэсэн найруулгыг судлах, мэдлэгээ дээшлүүлэх | Нийгмийн даатгалын Ерөнхий хууль хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | - | Сургалтанд 2-оос доошгүй удаа хамрагдах | 1.Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийн хэрэгжүүлэх зорилгоор баталсан дүрэм журам, заавар, аргачлалын сургалтанд хамрагдсан.<br>2.Улсын байцаагчийн шалгалтад оролцох ажилтнуудад зориулсан мэргэжил арга зүйгээр хангах сургалтанд хамрагдсан. | 2024.06.03<br><br>2024.10.28-2024.11.23 | |
| 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгээ дээшлүүлэх | - | Цахим сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байх | 1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх сургалтанд хамрагдсан.<br>2. Төрийн албан зөвлөлөөс пүрэв гариг бүр зохион байгуулдаг 7.4 .10 вевинар сургалтад ZOOM-ээр тогтмол хамрагдсан.<br>3. Аймгийн прокурорын байгууллагаас зохион байгуулсан " Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих, зөрчлийг шалгахад анхаарах асуудал." сэдэвт сургалтанд хамрагдсан.<br>4.Аймгийн прокурорын байгууллагаас зохион байгуулсан "Зөрчлийн нөхцөл байдал, гарч байгаа нийтлэг зөрчил, анхаарах асуудал" зөвлөгөөнд хамрагдсан. | 2024.01.05<br><br>2024.05.28<br><br>2024.12.13 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Өөрийгөө хөгжүүлж, бусадтай мэдлэг чадвараа хуваалцах | Өөрийгөө хөгжүүлж, бусадтай мэдлэг чадвараа хуваалцаж ажиллах | - | Мэдлэгээ дээшлүүлсэн байх | 1.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх баталгаажуулах шалгалтанд амжилттай оролцож эрхээ баталгаажуулсан.<br>2.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтанд орж 3 хөнгөлөлттэй болсон. | 2024.11.23-2024-11.24<br>2024.12.04-2024.12.05 | |